

Ц.БАТБАЯР “ХХ ЗУУНЫ ЭХЭН ХАГАСЫН МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦАА” НОМЫН ШҮҮМЖ

*К.Дэмбэрэл**

Доктор, профессор Ц.Батбаярын “ХХ зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” нэгэн сэдэвт судалгааны зохиолыг Оросын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол судлал, будда судлал, түвд судлалын хүрээлэнгээс эрхлэн орос хэл дээр 2002 онд 14.5 хэвлэлийн хуудсаар хэвлэн гаргалаа.

Энэхүү судалгааны бүтээл нь 5 бүлэг, оршил, ном зүй гэсэн хэсгээс бүрдсэн. Юуны өмнө, зохиогчийн тухайд цөөн хэдэн үг хэлэхийг зорилоо.

Монголын нийгмийн бүхий л амьдрал үзэл сурталаас ангид бичигдэх болсон үеэс судалгааны шинжтэй дорвитой бүтээлийг туурвих болсон дунд үеийн судлаачдын нэг нь доктор, профессор Цэдэндамбын Батбаяр юм. Олон улсын харилцааны түүх, орчин үеийн олон улсын харилцаа болон дорно дахины асуудлаар бичсэн ном зохиолууд, олон тооны өгүүлэл нийтлэлүүд нь түүнийг авьяаслаг, нөр их хөдөлмөрч эрдэмтэн гэдгийг харуулж байна.

Ц.Батбаярын “ХХ зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” зохиолд Японы архивын материалуудыг өргөн ашиглаж бичсэн нь харьцуулсан дүгнэлт хийх боломжийг зохиогчид олгожээ. Ингэснээрээ монголчуудад урьд өмнө нь бүрхэг байсан үйл явдал, баримтуудыг тодруулахад чухал ач холбогдолтой болж байгаа юм. Ц.Батбаярын гадаад хэлний өндөр мэдлэг нь хөгжилтэй орнуудын судлаачдын судалгааны онол арга зүйг монголд нэвтрүүлэхэд гол түлхүүр болж байгаа билээ.

“ХХ зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” бүтээлийн редактораар түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, Л.В.Курас нар ажиллажээ. Мөн уг бүтээлд доктор профессор Б.В. Базаров, С.И.Кузнецов нар өөрсдийн саналыг өгсөн.

Зохиолын оршил хэсэгтээ зохиогч XIX зууны 2-р хагасаас ХХ зууны эхэн хүртэлхи үеийн Орос, Япон, Хятад улсуудын хоорондын харилцаа, гадаад бодлого, тухайлбал, Солонгосын хойг, Тайвань, Сахалин, Курилийн арлуудын тухайд дээрхи улсуудын бодлогыг нарийн дэс дараатай тодорхойлон бичжээ. Японы зүгээс Солонгосын хойг,

*К.Дэмбэрэл – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Орос, Хятадтай харилцах харилцаандаа ямар байр суурьтай байсныг япон эх сурвалжаас нь гаргаж тавьжээ. Тэрээр 1873 онд японы засгийн газрын удирдагчдын нэг Тошимичи Окубо энэ талаар “Гадаад харилцаанд манайд хамгийн чухал улсууд бол Орос, Их Британи ... Тэдэнтэй харилцах харилцаа маань маш бүрхэг байгаа. Хэрвээ бид өөрийн тусгаар тогтнолоо бэхжүүлэх арга хэмжээ эс авбаас, Орос улс манайд довтлох арга хэмжээ авах бий гэхээс л эмээж байна. Хэрвээ бид одоо Солонгост довтлох аваас Орос нь Япон, Солонгос хоёрыг нэгэн зэрэг хялбар залгичихна. Тиймээс бидний хувьд одоо Солонгос руу довтлох нь цагаа олоогүй зүйл. Харин цаг нь ирэхээр аяндаа болно” гэж бичсэнийг ишлэл болгожээ. Үүгээрээ зохиогч Японы гадаад бодлогын түүхэн хувьслын эхлэлийг маш оновчтой тодорхойлсон.

“1870-аас 1890-ээд онуудад Япон улс нь өөрийн улс төр, батлан хамгаалах чадавхиа нэмэгдүүлэх дэс дараатай арга хэмжээг авахын зэрэгцээ Герман, АНУ, Орос, Их Британи зэрэг улсуудтай эрх тэгш гэрээг байгуулж гадаад тогтвортой байдлаа хангаж чаджээ” гэсэн дүгнэлтээрээ зохиогч түгжигдмэл Япон орон хэрхэн “нээгдэж” өөрийн чадавхиа нэмэгдүүлсэн түүхэн хөгжлийн гарааг гаргаж тавьсан.

Харин 1890 оноос хойш Японы гадаад бодлого нь эх газрын Ази руу чиглэгдэх болжээ. Энэ бодлого нь юуны түрүүнд Оросын сонирхолтой зөрчилдөж эхэлсэн. Оросын нөлөө голлож байсан Солонгосын хойг, Зүүн Хойд Хятадад энэ зөрчил илүүтэй гарч ирсэн. Уг зөрчлийг намжаах эсвэл улам идэвхжүүлэх улс төрийн хүчнүүд тухайн хоёр улсын дотор идэвхитэй ажиллаж байсныг зохиогч бүтээлдээ тусгасан. Гэхдээ зөрчлийг арилгахад Оросууд санаачлага багатай байсан ба Японы зүгээс уг зөрчлийг зохицуулахаар өндөр хэмжээнд хүч чармайлт гаргаж байсан талаар энэ зохиолд зохих баримтаар харуулсан. Энэ утгаараа зохиогч 1905 оны Орос-Японы дайны эхлэл явц, төгсгөлийн асуудлыг хөндөж тавьсан. 1905 оны Орос-Японы дайны дараагаар хүчтэй тавигдах болсон асуудал нь Орос, Япон, Хятадын хувьд Манжуурын асуудал болжээ. Онцлог нь эдгээр асуудлууд ийм хурцаар оросын түүх бичлэгт тусгагдаж байсангүй.

Номын эхний бүлэг нь 1900-1919 оны үйл явдлуудыг хамарч, Зүүн Азид Орос, Японы сонирхлын хүрээгээ харилцан тохиролцсон үеийг буюу 1907-1916 онуудыг бүхэлд нь тусгасан. Өөрөөр хэлбэл, 1907 оны 7-р сарын 30-ны, 1910 оны 7-р сарын, 1912 оны 7-р сарын Орос, Японы гэрээнүүд болон 1916 онд 2 улсын хооронд тогтоосон холбоотны гэрээнүүдийн талаар тайлбарлаж, уг гэрээний гол санаа

болох сонирхлын хүрээг зааглах асуудлуудыг түлхүү гаргаж тавьсан. Энэ хэсэгт гол нь 1905 оны дайнаас хойш Орос, Япон хоёр нь дотоод, гадаад хүчин зүйлийн улмаас харилцан бие биеэ ойлголцоод зогссонгүй холбоотон болон хувирсан хэмээн тодорхойлсон. Энэ үе бол Монголд нэн хамааралтай үе. Эдгээр гэрээнүүдээр Монгол нь дээрхи хоёр орны сонирхлын хүрээнд хуваагдсан билээ.

“Монголын тусгаар тогтнол ба Япон улс” хэмээх 2-р хэсэгтээ 1911-1912 оны Монголын ҮЭЧ-ний хувьсгалын дараахи үеийн Богд Хаант Монгол улсын засгийн газраас улс орныхоо тусгаар тогтнолыг их гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх талаар чармайн зүтгэж байсны нэг жишээ болох Японтой харилцах талаар нэлээд шийдвэртэй ажиллаж байсныг өгүүлсэн. Монгол орны улс төрийн амьдрал, гадаад бодлогын талаар Токио зохих мэдээлэл авч байжээ гэдгийг ч харуулсан. Энэ үед Япон нь Оростой тогтоосон удаа дараагийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд л Монголтой “харилцаж” байжээ гэсэн дүгнэлт хийжээ. Өөрөөр хэлбэл Япон нь гэрээндээ үнэнч байсан гэдгийг зохиогч баталсан.

Зохиолд Монгол, Японы “албан бус” харилцааны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн. 1921 оныг хүртэл Нийслэл Хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан Японы пүүсүүд болон хувь хүмүүс нь Монголын талаар тодорхой мэдээллийн эх сурвалж болж байжээ. Тухайн үед Монголд түр суурьшиж байсан япончууд нь голчлон Сибирээс орж ирсэн дүрвэгсэд байсан хэмээн зохиолд тэмдэглэсэн.

Олны сонирхол татсан “Пан монголын хөдөлгөөний” талаар сонирхолтой олон дүгнэлтүүд хийсэн ба энэ сэдэв нь одоо ч судлаачдын хараанд байсаар буй сэдэв билээ. Тухайн үед уг хөдөлгөөнд Япон улс тодорхой сонирхол илэрхийлж зохих дэмжлэг үзүүлж байсан талаар дэлгэрэнгүй бичжээ. Гэхдээ албан ёсоор уг хөдөлгөөнтэй холбоогүй хэмээн давхар мэдэгдэж байсан. Энэ үед Японы тагнуулын сүлжээ нь Владивостокоос Эрхүү хүртэлхи төмөр замын бүх өртөөнүүд дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байжээ. Түүгээр дамжуулан Читад төвлөрсөн “Пан монголын хөдөлгөөний” талаархи мэдээллийг ч ихээр цуглуулж байжээ.

Зөвлөлт засгаас Зүүн Азид явуулсан бодлогын талаар, ялангуяа Японтой холбоотой асуудлуудыг тусгайлан авч үзсэн нь тухайн үеийн Монголын улс төрийн нөхцөл байдлыг бүрэн тодорхойлоход чухал ач холбогдолтой болжээ. Зөвлөлт засгийн эхний жилүүдэд Японы 73 мянган цэрэг бүхий хүчин Алс Дорнодын нутгаар цөмрөн орж ирсэн, түүний зорилго, цэргээ буцаан татсан нөхцөл зэргийг товч бөгөөд

тодорхой харуулсан. Сонирхолтой нь гэвэл Барон Унгерн Монголд довлон орж ирэхэд түүний удирдлагад 50 орчим япончууд байсан ба тэдгээрээс 20 орчим нь Унгернийг ялагдах хүртэл цуг явжээ. Барон Унгерний Монголд орж ирсэн нь японы зүгээс ямар нэг хатгалга байгаагүй хэмээн зохиогч үзжээ. Ер нь урьд өмнө нь цагаантны цэргийн бүрэлдэхүүний талаар тодорхойлсон бүтээл хараахан гараагүй байсан билээ. Харин 1925 он гэхэд Зөвлөлт, Японы харилцааг хэвийн болгох хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зуржээ.

“Жан Золин ба Япон улс” хэмээх хэсэг нь Зүүн Хойд Хятадад байрласан японы цэргийн хүчний зүгээс болон ер нь Япон улсаас Хятадын цэргийн бүлэглэлүүдтэй тухайлбал, Жан Золин мэтийн генералуудтай хэрхэн харьцан ажиллаж байсныг, Манжуур, Өвөр Монголыг Хятадаас салган тусгаар улс болгох бодлого хэрхэн хэрэгжсэн зэргийг өгүүлжээ.

“МАНТЭЦУ ба МАНМО” буюу “Өмнөд Манжуурын төмөр зам” компаний үйл ажиллагааг ялангуяа, уг компаний бүрэлдэхүүнд байсан судалгааны газрын талаар тодорхой бичигджээ. Уг судалгааны газраас 1940 онд японы эсрэг дайн хийх хятадын чадавхийн талаар судалгааг хийснийг дурдсан. Манжуурын статусын талаар Японы зүгээс баримталж байсан бодлогыг ч тодорхойлсон. Одоо хүртэл судлаачдын анхаарлыг татсаар буй “Танакагийн меморандум”-ын талаар япон эх сурвалжууд ашиглан дэлгэрэнгүй бичжээ. “Гадаад Монголын талаархи Японы сонирхол 1925-1931” гэсэн хэсэгт ЗХУ-БНМАУ, БНМАУ-Япон, БНМАУ-Хятад, ЗХУ-Хятад гэсэн олон талын харилцааны эмзэг үеийн чухал асуудлуудыг хөндөн бичсэн. Энд монгол, японы архивын материалуудыг зохиогч өргөнөөр ашиглажээ. Сонирхолтой нь японы томоохон улс төрчид, дипломатууд Монголын (БНМАУ) тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх нь хэрэгтэй гэдгийг номлож байсныг ч энд оруулжээ.

Зохиогч “XX зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” номондоо 1932-1936 онуудын үйл явдлуудыг нэлээд олон талаас харж бичсэн. Өмнөд Манжуурын төмөр замыг (МАНТЭЦУ) тойрсон ашиг сонирхлын өрсөлдөөн ширүүссэн нь Зүүн Хойд Хятадад цэргийн түрэмгийлэл эхлэх, Манжуурын үйл явдал идэвхжих, Манж-Го улс бий болох гол нөхцөл болсон гэдгийг баталсан. Япон улс Манжуурыг цэргийн хүчээр эзэлсэн, Үндэстний Лиги-ээс гарсан, АНУ-тай зөрчилдөж эхэлсэн зэрэг үйл явдлууд ч оржээ. Манжуурт, Өвөр Монголд голлон байрласан Японы цэргийн их хүч болох Квантуны армийн талаар

тэдний удирдлага, үйл ажиллагааны болон Өвөр Монголын лидерүүд, тухайлбал Дэ-Вангийн байр суурийн талаар, Манж-Го болон Өвөр Монголын харилцааны тухайд дэлгэрэнгүй өгүүлдсэн. Өвөр Монголчуудын улс төрийн хувьд тусгаар байх үзэл бодлыг нь япончууд аль болох бүрэн дүүрэн ашиглахыг зорьж байжээ. 1932-1934 оны Зөвлөлт-Японы харилцаа, Зөвлөлт-Монголын 1934 оны аман гэрээ, БНМАУ ба Манж-Го улсын хоорондын хилийн маргааны асуудлууд, Зөвлөлт Японы шууд оролцоо зэргийг дэлгэрэнгүй бичжээ. Манжуурын 2-р бага хурал, Сталин, Гэндэн нарын Москвагийн хэлэлцээрийн талаар ч өгүүлжээ. “1936 оны Монгол-Зөвлөлтийн гэрээ ба Япон улс” гэсэн хэсэгт уг гэрээний талаархи Зөвлөлт, Хятад, Японы байр суурийг тодруулсан.

Номын IV бүлэг нь 1937-1939 онуудыг хамран бичигджээ. Хэдийгээр богино хугацааны асуудал боловч үйл явдлын хувьд ярвигтай он жилүүд байсныг энэ хэсгээс ойлгож болно. “Япон-Хятадын дайн ба БНМАУ-ын геостратегийн өсөлт” хэмээн нэрлэгдсэн хэсэгт БНМАУ бүс нутгийн улс төрийн амьдралд хэр хурдан татагдан орсныг гэрчилж байна. Халх голын дайны эхлэлийн үеийн БНМАУ-ын дотоод улс төрийн амьдрал, Монголын талаархи Москва, Токиогийн зөрчлийн тухайд архивын шинэ материалууд дээр түшиглэн бичжээ. Цаашлаад Халх голын дайнд нөлөөлсөн олон улсын хүчин зүйлүүд болон уг дайныг зогсоох талаар Молотов, Того нарын хэлэлцээрийн тухайд дэлгэрэнгүй өгүүлдсэн. Мөн хил тогтоох 4 талын хэлэлцээр болон уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн, явц, үр дүнгийн талаар нэлээд дэлгэрэнгүй бичигдсэн.

Номын V бүлэг буюу төгсгөлийн бүлэгт 1941-1945 онуудын үйл явдлыг хамарсан ба голлон “эх орны дайны” үеийн Зөвлөлт-Японы харилцаан дахь БНМАУ-ын асуудлуудыг хөндөн бичсэн. Энэ бүлгийн 2-р хэсэгт ЗХУ-аас Гоминданы Хятадтай БНМАУ-ын статус-кво-гийн талаархи яриа, хэлэлцээр, Гоминданыг Хятадын зүгээс БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн зэрэг асуудлууд архивын баримтад тулгуурлан бичигджээ.

Энэ зохиолд олон асуудлууд дээр т.н буюу (так называемых) “гэгдэх” хэмээх үгийг хэрэглэсэн нь агуулгыг бүрхэгдүүлэх буюу тодорхойгүй болгоход хүргэсэн байж болох талтай. Гэхдээ оросын түүх бичлэгт өргөн тохиолддог зүйл тул энэ бүтээлд агуулгын хувьд ямар нэг нөлөөтэй зүйл бус юм.

Доктор, профессор Ц.Батбаярын “XX зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” судалгааны зохиол нь Монголын гадаад

харилцааны түүхийг судлан хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан бүтээл болжээ.

XX зууны эхэн хагас ялангуяа, 1940-өөд оныг хүртэлхи үе бол Монголын түүхийн нарийн ээдрээтэй, түвэгтэй үе байлаа. Чухам энэ үеийн түүхийн гол асуудлууд болох Монгол улсын гадаад бодлого, түүний гадаад хүчин зүйлийн түүхэн үнэнийг нь тодруулах үүднээс зоригтой алхам хийж зохих хувь нэмрийг доктор, профессор Ц.Батбаяр нэгэнт оруулжээ.

Доктор Ц.Батбаяр энэ бүтээлээрээ нэг асуудлыг шийдвэрлэхдээ 3 улсын архивуудын материалуудыг харьцуулан дүгнэлт гаргасан нь урьд өмнө нь “эцэслэн” шийдэгдээгүй байсан түүхийн зарим асуудлуудад чухал ач холбогдолтой болсон. Энэ бүтээлийн хамгийн гол ач холбогдлын нэг бол Монгол улсын геостратегийн байрлал нь түүний түүхэнд хэрхэн нөлөөлж байсныг тодорхойлсон явдал юм.

Монгол улсын хөгжил нь өөрийнхөө геостратегийн өсөлт, бууралтаас хамааран хэрхэн өөрчлөгдөж байсныг их гүрнүүдийн бодлогоор батлан харьцуулсан нь Монголын түүх бичлэгт шинэ зүйл болжээ.